ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Дорноговь аймгийн Сайншанд сумын Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2020/75/СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
(Дорноговь аймаг Сайншанд сум)
2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: .70522734 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежерийн үүргийг
түр орлон гүйцэтгэгч Э.Энхцэцэг
Утас: 70523020 Цахим хаяг: injig78@yahoo.com
Аудитор: Б.Отгон-Өлзий
Утас: 99844655 Цахим хаяг: shilenbalanceaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ....... 3
2 Аудитын тайлан ....... 5
2.1. Оршил ....... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ....... 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ....... 6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ....... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ....... 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ....... 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ....... 7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....... 8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ....... 9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ....... 10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ....... 10
2.13. Шилэн дансны мэдээлэл ....... 11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ....... 11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ....... 11
3 Менежментийн захидал ....... 12
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан ....... 14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....... 14
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....... 16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ....... 18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....... 20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан **Error! Bookmark not defined.**
4.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт данс/ ....... 23

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2020.02.28 № 1-6/174

танай__________-ны №__________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ТОХИЖИЛТ-САЙНШАНД ХОТ
ТОХИЖИЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

## Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 сарын 01-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 04-нйи өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Шилэн баланс Аудит ХХК-ийн аудитор Б.Отгон-Өлзий хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 20-ны өдөр-ны өдрийн 09 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Дорноговь аймгийн Сайншанд сумын "Тохижилт-Сайншанд" хот тохижуулах газрын эрхэм зорилго нь гэр хороолол орон сууцны болон аж ахуйн нэгж байгууллагын ахуйн хуурай хог хаягдлыг ачиж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулган түрж булан устгах, гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ, нийтийн эзэмшлийн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, авто зам болон явган хүний зам талбайн цэвэрлэгээ ногоон байгууламжийн мод, бут зүлэгний усалгаа арчилгаа, нөхөн тарилт, золбин нохойн устгал, зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үүсгэн байгуулагчдын 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот

тохижилтын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хот тохижилт, хог зөөвөр

Байгууллагын төсвийн захирагч нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous" програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн, гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд 42 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдлийн түвшинг бага гэж үнэлэн 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн *1,882,409.4* мянган төгрөгөөс тооцон *37,648.*2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,129,266.3 мянган төгрөгөөр буюу 35.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 10,570.0 | 3,356.2 | -7,213.8 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 140,780.8 | 138,003.5 | -2777.3 |
| Үндсэн хөрөнгө | 5,381,405.7 | 7,070,207.7 | 1,688,802.0 |
| **Нийт хөрөнгө** | 3,178,736.0 | 4,308,702.3 | 1,129,966.3 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,178,736.0 | 4,308,702.3 | 1,129,966.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,178,736.0 | 4,308,702.3 | 1,129,966.3 |

Авлага дансны үлдэгдэл 7,213.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл орон нутгийн төсөвт төвлөрүүлснийг буцаан авснаас шалтгаалжээ. Удаан жилийн насжилттай авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,777.3 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материалын үлдэгдэл 2,810.5 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 4,879.7 мянган төгрөгөөр бууpч, түлш шатах тослох материалын үлдэгдэл 4,389.1 мянган төгрөгөөр сэлбэг хэрэгслийн үлдэгдэл 148.3 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Бараа материалын дансанд ашиглалтгүй олон жилийн хадгалалттай материалын үлдэгдэл байхгүй бөгөөд тайлант онд бэлтгэгдсэн материалын зайлшгүй ашиглагдах материалууд байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,688,802.0 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж 187,289.7 мянган төгрөгөөр, авто тээврийн хэрэгсэл 307,400.0 мянган төгрөгөөр, бусад хөрөнгө 1,137,862.0 мянган төгрөгөөр, тавилга 1,000.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1,137,862.0 мянган төгрөг нийтийн эзэмшлийн хөрөнгө, 187,289.7 мянган төгрөгийн барилга ашиглалтанд орсон бол 363,650.3 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, компьютер хандиваар буюу үнэ төлбөргүйгээр бэлтгэгдсэн байна. Үнэ төлбөргүй бэлтгэгдсэн хөрөнгө нь Дорноговь хөгжлийн сан болон Засаг даргын нөөц сангаас бэлтгэгдсэн байна..

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,308,702.3 мянган төгрөг болж 1,129,966.3 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд 1.130,966.3 мянган төгрөгийн ашигтай ажилласнаас шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүй хөрөнгө их хэмжээгээр бэлтгэгдэж тухайн аймаг орон нутгийн хөгжилт онцгой хувь нэмэр оруулж байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын тайлант онд 0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 12,800.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Хөрөнгө түрээслүүлсний орлогын 50 хувь | | 12,800.6 | 12,800.6 | |
| | | | | |
| | | | | |
| **Нийт дүн** | | | | |

Үндсэн үйл ажиллагааны болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө өгөгддөг бөгөөд Сайншанд сумын орон нутгийн тухайн байгууллагын харьяанд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг түрээсний орлогоос 50 хувийг байгууллагын дансанд төвлөрүүлэн зарцуулсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,141,771.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,141,771.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,082,685.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 59,086.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй зэрэгцүүлэн судлав.

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 613,285.2 | 613,285.2 | 0.0 | 100.0 |
| 2 | НДШ-ийн зардал | 88,525.9 | 87,007.0 | 1,518.9 | 98.3 |
| 3 | Гэрэл, цахилгаан | 984.5 | 899.3 | 85.2 | 91.3 |
| 4 | Түлш, халаалт | 9,561.8 | 9,560.8 | 1.0 | 100.0 |
| 5 | Цэвэр, бохир ус | 753.0 | 740.0 | 13.0 | 98.3 |
| 6 | Бичиг хэрэг | 1,050.8 | 1,232.4 | -181.6 | 117.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Тээвэр, шатахуун | 30,561.5 | 30,284.6 | 276.9 | 99.1 |
| 8 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 528.0 | 623.2 | -95.2 | 118.0 |
| 9 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,200.0 | 166,200.0 | 0.0 | 100.0 |
| 10 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 5,600.0 | 5,594.0 | 6.0 | 99.9 |
| 11 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 3,000.0 | 3,000.0 | 0.0 | 100.0 |
| 12 | Урсгал засвар | 59,512.9 | 59,512.9 | 0.0 | 100.0 |
| 13 | Дотоод албан томилолт | 479.8 | 479.8 | 0.0 | 100.0 |
| 14 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 161,728.5 | 161,697.8 | 30.7 | 100.0 |
| 19 | Нийт зардлын дүн | 1,141,771.9 | 1,140,117.0 | 1,654.9 | 99.9 |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,140,117.0. мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь .нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,518.9 мянган төгрөгөөр, гэрэл цахилгаан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг 30.5-276.9 мянган төгрөгөөр хэмнэж бичиг хэрэг, шуудан холбоо, интернетийн зардлыг 95.2-181.6 мянган төгрөгөөр хэтрүүлж нийт зардлыг 1,654.9 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй . холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 75102.4 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,800.6 мянга, нийт 87,902.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 3,184.4 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлд 210.0 мянга, багаж хэрэгсэл, тавилга худалдан авахад 6,470.4 мянга, урсгал засварын зардалд 8,504.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 300.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 65,878.1 мянга,нийт 84,546.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 3,356.1 мянган төгрөгийг улсын/орон нутгийн/ төсөвт төвлөрүүлсэн байна.

### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,100,294.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,100,294.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 2,100,294.2.мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

### 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 136 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,332,647.7 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66,7 хувьтай байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын өмч 2006 оноос хойш 9,8 дахин буюу 2,100,294.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн боловч 1 удаа байгууллагын дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт хийлгээгүй байна

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидал**

## 3.1. Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

3.1.1.Илрүүлэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газрын өмч 2,313,537,7 мянган төгрөг болж нэмэгдсэнийг байгууллагын дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт хийлгэх

Энэ нь оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл

Хуулийн хэрэгжилт хангалтгүй

3.1.3. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 “Монгол улсын иргэн, тус улсын нутагт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй” заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Санал өгөөгүй

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **151,350,801.96** | **141,359,640.19** |
| **33** | **АВЛАГА** | 10,570,000.00 | 3,356,173.00 |
| **335** | **Бусад авлага** | 10,570,000.00 | 3,356,173.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,570,000.00 | 3,356,173.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 140,780,801.96 | 138,003,467.19 |
| **354** | **Хангамжийн материал** | 140,780,801.96 | 138,003,467.19 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,212,720.00 | 10,402,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 95,080,912.31 | 90,576,644.19 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 20,052,894.65 | 20,201,226.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 12,434,275.00 | 16,823,397.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,027,385,220.44** | **4,167,342,677.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,027,385,220.44 | 4,167,342,677.25 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,014,121,220.44 | 4,153,883,121.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 88,475,820.00 | 348,963,901.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -13,820,129.61 | -8,207,784.11 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 1,006,613,247.95 | 1,328,833,247.95 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -723,882,510.27 | -878,440,571.97 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23,223,594.00 | 27,913,944.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -11,485,401.42 | -16,461,402.02 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,439,831.00 | 8,639,831.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,612,090.01 | -4,166,893.90 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,194,714,193.92 | 5,341,697,807.25 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,600,545,335.12 | -1,994,888,957.51 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 48,000,000.00 | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 13,264,000.00 | 13,459,555.56 |
| 39301 | Програм хангамж | 675,000.00 | 895,000.00 |
| 39302 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | -675,000.00 | -699,444.44 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,264,000.00 | 13,264,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,178,736,022.40** | **4,308,702,317.44** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **3,178,736,022.40** | **4,308,702,317.44** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,178,736,022.40 | 4,308,702,317.44 |
| 511 | Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 2,313,537,678.87 | 2,313,537,678.87 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,313,537,678.87 | 2,313,537,678.87 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 696,401,011.11 | 1,826,367,306.15 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 696,401,011.11 | 695,401,011.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,130,966,295.04 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 168,797,332.42 | 168,797,332.42 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,178,736,022.40** | **4,308,702,317.44** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,641,077,188.63** | **3,013,375,667.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **542,610,252.63** | **1,794,270,796.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 542,610,252.63 | 1,794,270,796.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 542,610,252.63 | 1,794,270,796.56 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 542,610,252.63 | 1,794,270,796.56 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,098,466,936.00** | **1,219,104,871.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 97,202,336.00 | 77,332,971.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 89,320,000.00 | 64,532,360.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,882,336.00 | 12,800,611.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 846,089,000.00 | 1,082,685,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 846,089,000.00 | 1,082,685,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 155,175,600.00 | 59,086,400.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 155,175,600.00 | 59,086,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,557,546,670.36** | **1,773,058,191.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,557,546,670.36** | **1,773,058,191.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,556,767,484.36 | 1,771,403,347.25 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 546,072,981.00 | 613,285,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 374,429,694.00 | 420,479,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,263,987.00 | 33,264,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 138,379,300.00 | 159,541,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 76,191,597.00 | 87,007,010.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 58,429,694.00 | 62,968,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,335,844.00 | 5,128,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,252,485.00 | 6,382,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 833,962.00 | 1,276,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,339,612.00 | 11,250,310.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,219,500.00 | 11,200,041.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,426,300.00 | 899,256.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,744,600.00 | 9,560,809.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,048,600.00 | 739,976.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 173,290,061.00 | 212,368,555.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,529,230.00 | 1,465,468.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 32,839,440.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 554,319.00 | 623,211.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 150,261,890.00 | 177,440,436.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 10,944,622.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 6,388,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 6,388,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,084,647.24 | 84,897,098.77 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 3,627,560.00 |
| 210604 | Урсгал засвар | 54,084,647.24 | 81,269,538.77 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 363,500.00 | 479,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 363,500.00 | 479,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 205,389,676.00 | 214,304,933.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,972,540.00 | 205,725,091.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,996,412.00 | 6,847,073.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 756,368.00 | 760,235.31 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 664,356.00 | 732,534.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 488,155,522.12 | 541,472,508.67 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 488,155,522.12 | 541,172,508.67 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 779,186.00 | 1,654,844.19 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 779,186.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 779,186.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,654,844.19 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,654,844.19 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **83,530,518.27** | **1,240,317,476.12** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 456,247,790.84 | 109,351,181.08 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 245,767,310.22 | 109,351,181.08 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 210,480,480.62 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -456,247,790.84 | -109,351,181.08 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-372,717,272.57** | **1,130,966,295.04** |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,104,466,936.00** | **1,229,674,871.00** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,104,466,936.00** | **1,229,674,871.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,202,336.00 | 87,902,971.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 95,320,000.00 | 75,102,360.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,882,336.00 | 12,800,611.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 1,001,264,600.00 | 1,141,771,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 846,089,000.00 | 1,082,685,500.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 155,175,600.00 | 59,086,400.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,099,769,636.00** | **1,223,564,521.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,099,769,636.00** | **1,223,564,521.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,088,420,450.00** | **1,218,553,503.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 546,072,981.00 | 613,285,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 374,429,694.00 | 420,479,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,263,987.00 | 33,264,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 138,379,300.00 | 159,541,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,614,397.00 | 87,007,010.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,852,494.00 | 62,968,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,335,844.00 | 5,128,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,252,485.00 | 6,382,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 833,962.00 | 1,276,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,339,612.00 | 11,250,310.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,387,500.00 | 11,200,041.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,426,300.00 | 899,256.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,744,600.00 | 9,560,809.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,216,600.00 | 739,976.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 154,964,369.00 | 201,524,657.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,006,450.00 | 1,232,448.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,994,000.00 | 33,468,998.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 554,319.00 | 623,211.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140,909,600.00 | 166,200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,599,600.00 | 5,804,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,599,600.00 | 5,804,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 68,468,785.00 | 71,596,862.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,000,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,499,298.00 | 2,999,980.00 |
| 210604 | Урсгал засвар | 63,969,487.00 | 67,596,882.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 363,500.00 | 479,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 363,500.00 | 479,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 220,584,196.00 | 227,355,933.31 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 212,167,060.00 | 218,776,091.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 240,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,996,412.00 | 6,847,073.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 756,368.00 | 760,235.31 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 664,356.00 | 732,534.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 365,122.00 | 300,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 365,122.00 | 300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,349,186.00** | **5,011,017.19** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 11,349,186.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,349,186.00 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | 00.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 5,011,017.19 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 1,654,844.19 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 3,356,173.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,697,300.00** | **6,110,350.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,697,300.00** | **6,110,350.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,697,300.00** | **6,110,350.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,697,300.00 | 6,110,350.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,697,300.00 | 6,110,350.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-4,697,300.00** | **-6,110,350.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,300,273,678.87 | 91,630,500.00 | 1,248,092,266.05 | 3,639,996,444.92 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,300,273,678.87** | **91,630,500.00** | **1,248,092,266.05** | 3,639,996,444.92 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 165,596,205.16 | 165,596,205.16 |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,797,332.42** | **696,401,011.11** | 3,178,736,022.40 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,797,332.42** | **696,401,011.11** | 3,178,736,022.40 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,797,332.42** | **695,401,011.11** | 3,177,736,022.40 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,130,966,295.04 | 1,130,966,295.04 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,313,537,678.87** | **168,797,332.42** | **1,826,367,306.15** | 4,308,702,317.44 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
| **0** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,141,771,900.00 | 1,140,117,055.81 | -1,654,844.19 | 99.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,141,771,900.00 | 1,140,117,055.81 | -1,654,844.19 | 99.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,141,771,900.00 | 1,140,117,055.81 | -1,654,844.19 | 99.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 613,285,200.00 | 613,285,200.00 | 00.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 420,479,700.00 | 420,479,700.00 | 00.00 | 100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,264,000.00 | 33,264,000.00 | 00.00 | 100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 159,541,500.00 | 159,541,500.00 | 00.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 88,525,900.00 | 87,007,010.00 | -1,518,890.00 | 98.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,968,300.00 | 62,968,300.00 | 00.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,128,800.00 | 5,128,800.00 | 00.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,382,800.00 | 6,382,800.00 | 00.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,276,800.00 | 1,276,800.00 | 00.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,769,200.00 | 11,250,310.00 | -1,518,890.00 | 88.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,299,300.00 | 11,200,041.00 | -99,259.00 | 99.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 984,500.00 | 899,256.00 | -85,244.00 | 91.3 |
| 210302 | Түлш, халаалт | 9,561,800.00 | 9,560,809.00 | -991.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 753,000.00 | 739,976.00 | -13,024.00 | 98.3 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 198,340,300.00 | 198,340,299.50 | -00.50 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,050,800.00 | 1,232,448.00 | 181,648.00 | 117.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,561,500.00 | 30,284,640.00 | -276,860.00 | 99.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 528,000.00 | 623,211.50 | 95,211.50 | 118.03 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,200,000.00 | 166,200,000.00 | 00.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 00.00 | 00.00 | #DIV/0! |
| **2105** | **Нормативт зардал** | 5,600,000.00 | 5,594,000.00 | -6,000.00 | 99.89 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,600,000.00 | 5,594,000.00 | -6,000.00 | 99.89 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,512,900.00 | 62,512,862.00 | -38.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 | 00.00 | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,000,000.00 | 2,999,980.00 | -20.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 59,512,900.00 | 59,512,882.00 | -18.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 479,800.00 | 479,800.00 | 00.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 479,800.00 | 479,800.00 | 00.00 | 100.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 | 00.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 161,728,500.00 | 161,697,843.31 | -30,656.69 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 153,685,200.00 | 153,676,091.00 | -9,109.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | 240,000.00 | 00.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 6,289,000.00 | 6,288,983.00 | -17.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 760,300.00 | 760,235.31 | -64.69 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 754,000.00 | 732,534.00 | -21,466.00 | 97.2 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,141,771,900.00 | 1,141,771,900.00 | 00.00 | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,141,771,900.00 | 1,141,771,900.00 | 00.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,082,685,500.00 | 1,082,685,500.00 | 00.00 | |

## 4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /нэмэлт данс/

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагд сан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагд сан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | 92,632,336.00 | | 84,546,798.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | 92,632,336.00 | | 84,546,798.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 92,632,336.00 | | 84,546,798.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 8,000,000.00 | | 3,184,358.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 8,000,000.00 | | 3,184,358.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | | | 210,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | | 210,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 16,762,000.00 | | 14,974,350.00 |
| 210602 | Тавилга | | | | 3,194,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | | | 3,276,350.00 |
| 210604 | Урсгал засвар | | 16,762,000.00 | | 8,504,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 67,505,214.00 | | 65,878,090.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 67,505,214.00 | | 65,320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | | | 558,090.00 |
| 210804 | Бараа, ажил үйлчилгээний зардал | | 365,122.00 | | 300,000.00 |
| 210805 | Бараа, ажил үйлчилгээний зардал | | 365,122.00 | | 300,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 104,042,226.00 | | 87,902,971.00 |
| **1320** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 104,042,226.00 | | 87,902,971.00 |
| 132001 | ТБӨБӨЭтгээдээс хандив | | 1,207,164.00 | | |
| 132007 | ЗДНСангаас | | 10,000,000.00 | | |
| 132013 | Дээд шатны төсөв үахирагчаас | | 86,159,890.00 | | 75102360.00 |
| 132019 | ТБҮҮАХүрээнд бий болсон орлого | | 6,675,172.00 | | 12800611.00 |